

2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН 4 ДҮГЭЭР АНГИЙН НЭГДМЭЛ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ДЭЛГЭРЭНГҮЙ БЛЮПРИНТ
Хугацаа 40 минут

ХУГАЦАА			СОНГОХ ДААЛГАВАР				ЗАДГАЙ ДААЛГАВАР				Нийт	Хувь
ДААЛГАВРЫН ТАВИЛ			Мэдлэг ойлголт	Чадвар	Хэрэглээ	Бүгд	Мэдлэг ойлголт	Чадвар	Хэрэглээ	Бүгд		
№	АТБХ	Суралцахуйн зорилт	Мэдлэг ойлголт	Чадвар	Хэрэглээ	Бүгд	Мэдлэг ойлголт	Чадвар	Хэрэглээ	Бүгд		
1	Унших	4.1б. Уншсан эхийн болон үлгэр, өгүүллэгийн бүтцийн холбоо хамаарлаас гол санааг ойлгосноо харуулах	1/1			1/1					1/1	3.3%
2		4.1з. Хурд, дууны өнгөө тохируулан урнаар уншиж, шүлгийн утгыг ойлгосноо харуулах	1/1	1/1		2/2					2/2	6.7%
3		4.1и. Уншсан зохиолын баатрын гадаад дүр байдлыг ургуулан бодож төсөөлөх	1/1	1/1		2/2		1/3		1/3	3/5	16.7%
4	Бичих	4.2ж. Бусдыг сайн сайхан зүйлд уриалж, бүтцийн дагуу уриалга бичих							1/4	1/4	1/4	13.3%
5	Хэл зүй, үгийн сан	4.4в. Ойролцоо утга, эсрэг утгатай үгийг найруулгад оновчтой хэрэглэн өгүүлбэр, эх зохиох	1/1			1/1		1/2		1/2	2/3	10%
6	Амьдрал	4.1а. Хүний биеийн араг ясны толгой, их бие, мөчдийн хэсгүүдийг зургаас ялган таних, үүргийг жишээгээр тайлбарлах	1/1			1/1					1/1	3.3%
7		4.1д. Тухайн орчин дахь амьд биес идэш тэжээлээрээ холбогддог болохыг тайлбарлах	1/1			1/1		1/3		1/3	2/4	13.3%
8	Юмс үзэгдэл	4.2б. Гэрэл үүсгэгч, бие, дэлгэц гурвын харилцан байрлалаас сүүдрийн хэмжээ хамаардаг болохыг тайлбарлах	1/1			1/1					1/1	3.3%
9		4.2и. Соронзонд татагддаг, татагддаггүй материалыг таньж тодорхойлох	1/1			1/1					1/1	3.3%
10		4.2ө. Батарей, чийдэн ашиглан өгсөн материалуудын цахилгаан дамжуулах чадварыг таньж тодорхойлох						1/2			1/2	6.7%
11		4.2р. Түгээмэл тохиолдох хатуу, шингэн, хийг таньж тодорхойлох, нэрлэх, жишээ гаргах							1/4		2/5	16.7%
12		4.2ү. Сургууль орчмын план зурахдаа юмсыг таних тэмдгээр дүрслэн зүг чигийг тэмдэглэх		2/2							1/1	3.3%

Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын ерөнхий боловсролын сургууль

ДААЛГАВРЫН ТОО, ОНОО	8/8	4/4		12/12		4/10	2/8		18/30	
ОНООНЫ ЭЗЛЭХ ХУВЬ	67%	33%		100%		67%	33%		100%	100%

ОНООНЫ ХЭВИЙН ТАРХАЛТ

Танин мэдэхүйн түвшин	Сонгох даалгаврын оноо	Задгай даалгаврын оноо	Нийт оноо	Нийт онооны эзлэх хувь
Мэдлэг ойлголт/ Ойлгох /	8		8	26%
Чадвар/ Хэрэглэх/	4	10	14	47%
Хэрэглээ /Задлан шинжлэх/		8	8	26%
Нийт	12	14	18	100%

ҮНЭЛГЭЭНИЙ ДААЛГАВРЫН ХАРИУ, ҮНЭЛЭХ СХЕМ

№	Суралцахуйн зорилт	Танин мэдэхүйн түвшин	Зөв хариулт А	Зөв хариулт Б	Оноо	Онооны тайлбар
МОНГОЛ ХЭЛ						
СОНГОХ ДААЛГАВАР						
1	4.1б. Уншсан эхийн болон үлгэр, өгүүллэгийн бүтцийн холбоо хамаарлаас гол санааг ойлгосноо харуулах	Мэдлэг ойлголт	Б	Б	1	Зөв хариулт сонгосон бол 1 оноо
2	4.1з. Хурд, дууны өнгөө тохируулан урнаар уншиж, шүлгийн утгыг ойлгосноо харуулах	Мэдлэг ойлголт	В	Б	1	Зөв хариулт сонгосон бол 1 оноо
3	4.1и. Уншсан зохиолын баатрын гадаад дүр байдлыг ургуулан бодож төсөөлөх	Мэдлэг ойлголт	В	Б	1	Зөв хариулт сонгосон бол 1 оноо
4	4.4в. Ойролцоо утга, эсрэг утгатай үгийг найруулгад оновчтой хэрэглэн өгүүлбэр, эх зохиох	Мэдлэг ойлголт	Г	Б	1	Зөв хариулт сонгосон бол 1 оноо
5	4.1з. Хурд, дууны өнгөө тохируулан урнаар уншиж, шүлгийн утгыг ойлгосноо харуулах	Чадвар	Б	Б	1	Зөв хариулт сонгосон бол 1 оноо
6	4.1и. Уншсан зохиолын баатрын гадаад дүр байдлыг ургуулан бодож төсөөлөх	Чадвар	А	Г	1	Зөв хариулт сонгосон бол 1 оноо
ЗАДГАЙ ДААЛГАВАР						

Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын ерөнхий боловсролын сургууль

7	4.1и. Уншсан зохиолын баатрын гадаад дүр байдлыг ургуулан бодож төсөөлөх	Чадвар	Чимэх Би сүлд модоо чимэх дуртай.	Төрөх Манай үнээ төрөх дөхсөн.	3	Үгийг бичих 1 оноо, өгүүлбэр зохиох 1 оноо
8	4.4в. Ойролцоо утга, эсрэг утгатай үгийг найруулгад оновчтой хэрэглэн өгүүлбэр, эх зохиох	Чадвар	Талх-Хүнсний зүйл Талхи-Арьс элдэх багаж	Савх-хоол идэх хэрэгсэл Савхи-Боловсруулсан арьс	2	Үг тус бүрийг зөв тайлбарласан бол 1 оноо
9	4.2ж. Бусдыг сайн сайхан зүйлд уриалж, бүтцийн дагуу уриалга бичих	Хэрэглээ	Эхлэл, гол, төгсгөл хэсэгтэй, үгийн тоо бүрэн,иалдаагүй бичсэн байна.	Эхлэл, гол, төгсгөл хэсэгтэй, үгийн тоо бүрэн, алдаагүй бичсэн байна.	4	Эхлэл, гол, төгсгөл хэсэг тус бүр 1 оноо, үгийн тоо хүрсэн, алдаагүй бол 1 оноо

ХҮН БА БАЙГАЛЬ

СОНГОХ ДААЛГАВАР

1	4.1а. Хүний биеийн араг ясны толгой, их бие, мөчдийн хэсгүүдийг зургаас ялган таних, үүргийг жишээгээр тайлбарлах	Мэдлэг ойлголт	А	В	1	Зөв хариулт сонгосон бол 1 оноо
2	4.1д. Тухайн орчин дахь амьд биес идэш тэжээлээрээ холбогддог болохыг тайлбарлах	Мэдлэг ойлголт	Б	А	1	Зөв хариулт сонгосон бол 1 оноо
3	4.2б. Гэрэл үүсгэгч, бие, дэлгэц гурвын харилцан байрлалаас сүүдрийн хэмжээ хамаардаг болохыг тайлбарлах	Мэдлэг ойлголт	Б	Б	1	Зөв хариулт сонгосон бол 1 оноо
4	4.2и. Соронзонд татагддаг, татагддаггүй материалыг таньж тодорхойлох	Мэдлэг ойлголт	В	В	1	Зөв хариулт сонгосон бол 1 оноо
5	4.2р. Түгээмэл тохиолдох хатуу, шингэн, хийг таньж тодорхойлох, нэрлэх, жишээ гаргах	Чадвар	Б	Б	1	Зөв хариулт сонгосон бол 1 оноо
6	4.2ү. Сургууль орчмын план зурахдаа юмсыг таних тэмдгээр дүрслэн зүг чигийг тэмдэглэх	Чадвар	В	В	1	Зөв хариулт сонгосон бол 1 оноо

ЗАДГАЙ ДААЛГАВАР

7	4.1д. Тухайн орчин дахь амьд биес идэш тэжээлээрээ холбогддог болохыг тайлбарлах	Чадвар	1в, 2а, 3б	1а, 2в, 3б	3	Харгазлаа бүр 1 оноо, нийт 3 оноо
---	--	--------	------------	------------	---	-----------------------------------

Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын ерөнхий боловсролын сургууль

8	4.2ө. Батарей, чийдэн ашиглан өгсөн материалуудын цахилгаан дамжуулах чадварыг таньж тодорхойлох	Чадвар	Цахилгаан, цахилгаан дамжуулагч	Цахилгаан цахилгаан тусгаарлагч	2	Зөв нөхсөн үг бүр 1 оноо
9	4.2р. Түгээмэл тохиолдох хатуу, шингэн, хийг таньж тодорхойлох, нэрлэх, жишээ гаргах	Хэрэглээ	Бодисыг усанд уусдаг, уусдаггүйг тэмдэглээд тайбарыг бичсэн байна.	Бодисыг усанд уусдаг, уусдаггүйг тэмдэглээд тайбарыг бичсэн байна.	4	Бодис тус бүр 1 оноо, нийт 4 оноо

НЭГДМЭЛ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ

А ХУВИЛБАР

НИЙТ ОНОО 30

ХУГАЦАА 60 МИНУТ

МОНГОЛ ХЭЛ ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

НЭГ. СОНГОХ ДААЛГАВАР

САНАМЖ: Эхийг анхааралтай уншиж ойлгосны дараа даалгаврыг гүйцэтгээрэй. Сонгох даалгавар бүр 1 оноотой.

Торх

Нэгэн хүү дүүрэн тостой торх гэртээ хүргэхээр өнхрүүлж явжээ. Өөд газар торхоо чуу ай өнхрүүлсээр хөтөл дээр гарч ирвэл гэр нь харагдаж байв. “Ингэж биеэ зовоож байхаар өөрийг нь явуулчихъя. Гэрийн гадаа түвэггүй хүрчих биз” гэж бодоод торхоо газрын уруу түлхчихжээ.

Том торх ойж бууж явсаар гэрээс өнгөрч, гүн жалганд тогтов. Хүү, жалган дотроос торхоо гаргах гэж өдөржин ноцолдоод дийлсэнгүй.

- 1. Хүү гэр лүүгээ юу зөөсөн бэ?
 А. Чулуу Б. Торх В. Жалга руу Г. Хүү
- 2. Хүү торхоо газрын уруу түлхэхдээ юу гэж бодсон бэ?
 А. Хурдан гэртээ харих минь
 Б. Жалганд аваачъя
 В. Ингэж биеэ зовоож байхаар өөрийг нь явуулчихъя. Гэрийн гадаа түвэггүй хүрчих биз”
 Г. Торхоо гэртээ аваачихаар өнхрүүлж явсан.
- 3. Хүү эцэст нь ямар үйл хийсэн бэ?
 А. Нэгэн хүү дүүрэн тостой торх гэртээ хүргэхээр өнхрүүлж явжээ.
 Б. Ингэж биеэ зовоож байхаар өөрийг нь явуулчихъя
 В. Хүү жалган дотроос торхоо гаргах гэж өдөржин ноцолдоод дийлсэнгүй.
 Г. Торх авсан.
- 4. Харх гэдэг үгтэй ижил бичлэгтэй үгийг сонгоорой.
 А. Торох Б. Төрөх В. Чимэх Г. Чимх
- 5. Хүү торхоо зөөхөд аль хэсэгт хэцүү байсан бэ?
 А. Өнхрүүлэхэд Б. Өөд газар торхоо өнхрүүлэхэд
 В. Жалганы уруу өнхрүүлэхэд Г. Хэцүү байгаагүй
- 6. Эхийн утгад тохирох зүйр цэцэн үгийг сонгоорой
 А. Гэм нь урдаа, гэмшил нь хойноо Б. Олон удаа бод, ганц удаа хий
 В. Сурсан бүхэн эрдэм, сураагүй бүхэн балай Г. Алдыг нь аваад атга дээр нь, атгыг нь аваад чимх дээр нь

ХОЁР. ЗАДГАЙ ДААЛГАВАР

- 7. Ижил дуудлагатай үгийг бичээд, тус бүрээр нь өгүүлбэр зохиогоорой. /3 оноо/
 савх-.....

- 8. Үгсийн утгыг тайлбарлан бичээрэй. /2 оноо/
 Талх-.....
 Талхи-.....
- 9. Хичээл номондоо шамдан суралцахыг уриалж, бүтцийн дагуу уриалга бичээрэй. Үгийн тоо 30-40 /4 оноо/

ХҮН БА БАЙГАЛЬ ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

НЭГ. СОНГОХ ДААЛГАВАР

САНАМЖ: Анхааралтай уншиж ойлгосны дараа даалгаврыг гүйцэтгээрэй.
Сонгох даалгавар бүр 1 оноотой.

- Зөв хариултыг сонгоорой.
Араг яс биеийн тулгуур болохоос гадна, биеийг хөдөлгөх үүрэгтэй.
А. Дотор эрхтнүүдийг хамгаалах Б. Хөл дээр зогсоох
В. Арьс тогтоодог Г. Булчин хөгжүүлдэг
- Хүний идэш тэжээлийн хэлхээг зөв сонгоорой.



- А. Үр-тахиа Б. Үр-тахиа-хүн В. Үр-хүн Г. Үр
- Бие гэрэл үүсгэгч рүү ойртох тутам сүүдрийн хэмжээ байна.
А. Жижиг Б. Том В. Адил Г. Гарахгүй
 - Соронзоор юуг ялган авч болдог вэ?
А. Хуванцар зүйл В. Төмөрлөг зүйл С. Модлог зүйл
 - Цахилгаан дамжуулдаггүй биетийг сонгоорой.
А. Хөнгөнцагаан Б. Бал
 - Усанд ороход угаалгын өрөөний толь цантдаг. Доорх үзэгдлийн аль нь вэ?
А. Уурших үзэгдэл Б. Хайлах үзэгдэл
В. Конденсацлах Г. Царцах үзэгдэл

ХОЁР. ЗАДГАЙ ДААЛГАВАР

- Амьд биеийн идэш тэжээлийг зөв харгалзуулаарай. /3 оноо/
1. Сохор номин А. Мах
2. Чоно Б. Самар
3. Хэрэм В. Үндэс
- Металл нь дамжуулж байгаа учраас “,” юм. /2 оноо/
- Дараах зүйлсийг усанд уусах, уусахгүйг + тэмдэгдлэж, тайлбарлаж бичнэ үү./4 оноо/

	Усанд уусдаг	Яагаад усанд уусаж байгааг тайлбарлана уу?	Усанд уусдаггүй	Яагаад усанд уусахгүй байгааг тайлбарлана уу?
Төмрийн үртэс				
Элсэн чихэр				
Шороо				
Кофе				

НЭГДМЭЛ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ

Б ХУВИЛБАР

НИЙТ ОНОО 30

ХУГАЦАА 60 МИНУТ

МОНГОЛ ХЭЛ ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

НЭГ. СОНГОХ ДААЛГАВАР

САНАМЖ: Эхийг анхааралтай уншиж ойлгосны дараа даалгаврыг гүйцэтгээрэй. Сонгох даалгавар бүр 1 оноотой.

Олз

Оготно нүхнээсээ гарч, “Муужгайд харагдах вий” гэж айж явсаар боовны хэлтэрхий олжээ. Олзоо үүрэндээ хүргэх гэтэл хүч дутаж гэнэ. Дааж ядан ноцолдож байтал аалз хүрч ирээд: - Чи ингэж биеэ зовоож байхаар нөхдөө дуудаж ирүүлээч, чамд амар биш үү? Гэхэд - Аалз чи учрыг мэдэхгүй байна. Нөхдөө дуудвал олзоо хуваах хэрэгтэй болно. Би энэ сайхан зуушийг ганцаараа идэх ёстой гэж оготно учирлав.

Оготно боовны хэлтэрхийг үүрэндээ аваачих гэж ноцолдсоор ядрахын туйлыг үзжээ. Энэ үеэр элээ нисэн ирж, олзны боовыг шүүрэн оджээ.

- 1. Оготно нүхнээсээ гарч яваад юу олсон бэ? А. Муужгай Б. Боов В. Олз Г. Аалз
2. Оготно нүхнээсээ гарахдаа юу гэж бодсон бэ? А. Аалз харагдах вий. Б. Муужгайд харагдах вий. В. Би ганцаараа идэх ёстой. Г. Олзоо хаясан.
3. Оготно боов аваачих гэсээр яасан бэ? А. Энэ үеэр элээ нисэн ирсэн. Б. Оготно боовны хэлтэрхийг үүрэндээ аваачих гэж ноцолдсоор ядрахын туйл үзсэн. В. Аалз чи учрыг мэдэхгүй байна. Г. Олзоо хаясан.
4. Төрх гэдэг үгтэй ижил бичлэгтэй үгийг сонгоорой. А. Орох Б. харах В. савх Г. сэрэх
5. Оготно олз олоод үүрэндээ хүргэхэд юу дутсан бэ? А. Дааж ядан ноцолдож байтал аалз ирсэн. Б. Олзоо үүрэндээ хүргэх гэтэл хүч дутаж гэнэ. В. Нөхдөө дуудвал олзоо хуваах болно. Г. Олз олоогүй
6. Эхийн утгад тохирох зүйр цэцэн үгийг сонгоорой. А. Олны хүч оломгүй далай Б. Санаа нь дэлхий, чадал нь мэлхий В. Өөдөө хаясан чулуу, өөрийн толгой дээр Г. Харамласан юм, хар нохойны идэш

ХОЁР. ЗАДГАЙ ДААЛГАВАР

- 7. Ижил дуудлагатай үгийг бичээд, тус бүрээр нь өгүүлбэр зохиогоорой. /3 оноо/ Сэрх-.....
8. Үгсийн утгыг тайлбарлан бичээрэй. /2 оноо/ Савх-..... Савхи-.....
10. Ном уншихыг уриал, уриалж, бүтцийн дагуу уриалга бичээрэй. Үгийн тоо 30-40 /4 оноо/

ХҮН БА БАЙГАЛЬ ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

НЭГ. СОНГОХ ДААЛГАВАР

САНАМЖ: Анхааралтай уншиж ойлгосны дараа даалгаврыг гүйцэтгээрэй. Сонгох даалгавар бүр 1 оноотой.

- Зөв хариултыг сонгоорой.
Араг яс биеийн тулгуур болохоос гадна, дотор эрхтнүүдийг хамгаалах, үүрэгтэй.
А. Арьс тогтоодог Б. Хөл дээр зогсоох
В. Биеийг хөдөлгөх Г. Булчин хөгжүүлдэг
- Чононы идэш тэжээлийн хэлхээг зөв бичсэнийг сонгоорой.



- А. Өвс-хонь-чоно Б. Өвс-чоно В. Хонь-чоно Г. Өвс-чоно

- Бие гэрэл үүсгэгчээс холдох тусам сүүдрийн хэмжээ байна.
А. Том Б. Жижиг В. Өөр Г. Гарахгүй
- Аль материал соронзонд татагддаг вэ?
А. Мод В. Төмөр С. Шил
- Цахилгаан дамжуулдаг биетийг сонгоорой.
А. Шил Б. Төмөр
- Усанд ороход угаалгын өрөөний толь цантдаг. Доорх үзэгдлийн аль нь вэ?
А. Уурших үзэгдэл Б. Хайлах үзэгдэл
В. Конденсацлах Г. Царцах үзэгдэл

ХОЁР. ЗАДГАЙ ДААЛГАВАР

- Амьд биеийн идэш тэжээлийг зөв харгалзуулаарай. /3 оноо/
1. Загас А. Замаг
2. Бар Б. Өвсөн
3. Туулай В. Мах
- Металл нь дамжуулахгүй байгаа учраас “.....,” юм. /2 оноо/
- Дараах зүйлсийг усанд уусах, уусахгүйг + тэмдэглэж, тайлбарлаж бичнэ үү./4 оноо/

	Усанд уусдаг	Яагаад усанд уусаж байгааг тайлбарлана уу?	Усанд уусдаггүй	Яагаад усанд уусахгүй байгааг тайлбарлана уу?
Шороо				
Элсэн чихэр				
Шороо				
Ааруулын үйрмэг				

